

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/214/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЦЭЭЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор: Б.Адъяасүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: adiyasurenb@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн:

Уваа уул аудит ХХК, захирал: Ч.Мөнхтуяа

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2026.02.25 № 01/185
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН ЦЭЭЛ СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
ЖДЭЛГЭРМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн "Хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 254 дүгээр тогтоолоор Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн хүүхдийн нэг өдрийн үдийн хоолны түүхий эдийн зардлыг 2.5 мянган төгрөг, дотуур байранд амьдрах дунд болон ахлах ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6.3 мянган төгрөг, бага ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон байна.

Аудитын гол асуудал

Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад Айтүүлс ХХК-аас нийгмийн хариуцлагын хүрээнд мэдээллийн технологийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор орчин үеийн сургалтын 41,399.7 мянган төгрөгийн иж бүрэн 13 ширхэг зөөврийн компьютер, ухаалаг дэлгэц хандивласан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт бүхий нийт 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 85.9 хувиар үнэлэгдсэн байна.

4126020202

**Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	345,882,342.83	420,637,205.08
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	269,237,355.59	334,383,644.01
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	269,237,355.59	334,383,644.01
3121	Төгрөг	269,237,355.59	334,383,644.01
31211	Төрийн сангийн харилцах	269,237,355.59	334,383,644.01
33	АВЛАГА	340,943.97	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	241,699.00	-
335	Бусад авлага	99,244.97	-
33520	Хувь хүмүүсээс авах авлага	99,244.97	-
35	БАРАА МАТЕРИАЛ	76,304,043.27	86,253,561.07
351	Түүхий эд материал	278,426.00	278,426.00
35110	Тусгай зориулалттай материал	278,426.00	278,426.00
354	Хангамжийн материал	74,595,617.27	84,545,135.07
35410	Бичиг хэргийн материал	3,007,000.00	2,575,000.00
35420	Аж ахуйн материал	3,140,600.00	2,470,000.00
35460	Хүнсний материал	1,428,330.00	-
35470	Бусад хангамжийн материал	67,019,687.27	79,500,135.07
35600	Мал амьтад	1,430,000.00	1,430,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,573,400,021.75	2,539,252,051.90
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,573,400,021.75	2,539,252,051.90
392	Биет хөрөнгө	2,488,265,021.75	2,469,706,051.90
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,423,251,471.00	2,452,601,471.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(300,356,749.21)	(359,987,673.25)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	10,000,000.00	10,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(5,666,666.44)	(6,666,666.40)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	297,219,928.20	347,623,490.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(119,353,662.95)	(133,526,399.20)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	130,062,896.56	117,701,063.98
39208	Хуримтлагдсан элэгдэл	(47,574,733.39)	(49,867,627.05)
39214	Бусад үндсэн хөрөнгө	96,155,397.00	91,501,395.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(15,634,839.66)	(19,834,982.82)
39217	Ном	20,161,980.64	20,161,980.64
393	Биет бус хөрөнгө	85,135,000.00	69,546,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	85,135,000.00	69,546,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,919,282,364.58	2,959,889,256.98
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	287,924.35	1,397,667.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	287,924.35	1,397,667.00
413	Өглөг	287,924.35	1,397,667.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	287,924.35	734,482.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	663,185.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,918,994,440.23	2,958,491,589.98

**Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

51	Засгийн газрын хувь оролцоо	2,918,994,440.23	2,958,491,589.98
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	602,708,368.54	602,708,368.54
51101	Өмч: - төрийн	602,708,368.54	602,708,368.54
512	Хуримтлагдсан үр дүн	1,577,935,887.01	1,617,433,036.76
51210	Өмнөх үеийн үр дүн	1,423,149,073.05	1,577,935,887.01
51220	Тайлант үеийн үр дүн	154,786,813.96	39,497,149.75
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	738,350,184.68	738,350,184.68
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,919,282,364.58	2,959,889,256.98

Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,151,290,358.10	2,510,015,407.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	74,025,258.10	95,437,207.80
120	Нийтлэг татварын бус орлого	74,025,258.10	54,037,447.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	4,137,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,137,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	63,961,628.10	37,420,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	10,063,630.00	12,480,447.80
122	Тусламжийн орлого	-	41,399,760.00
122001	Хандив тусламж /дотоод/	-	41,399,760.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,077,265,100.00	2,414,578,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,773,376,600.00	2,154,298,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,773,376,600.00	2,154,298,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,780,200.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,780,200.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	300,108,300.00	260,280,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	300,108,300.00	260,280,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,993,840,327.25	2,470,518,258.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,993,840,327.25	2,470,518,258.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,929,168,870.89	2,470,123,515.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,221,451,492.18	1,604,426,756.52
210101	Үндсэн цалин	795,880,282.23	988,511,749.75
210102	Нэмэгдэл	401,565,609.95	592,126,306.77
210104	Урамшуулал	24,005,600.00	23,788,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	155,408,757.00	197,412,592.45
210201	Тэтгэврийн даатгал	105,100,824.48	135,129,178.74
210202	Тэтгэмжийн даатгал	14,276,784.16	17,673,698.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,152,384.61	8,233,793.33
210204	Ажилгүйдлийн даатгал	6,013,372.83	7,275,184.45
210205	Эрүүл мэндийн даатгал	23,865,390.92	29,100,737.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	250,970,419.89	254,885,357.40
210301	Гэрэл, цахилгаан	16,361,545.64	21,052,845.18
210302	Түлш, халаалт	229,608,874.25	231,182,742.39
210303	Цэвэр, бохир ус	5,000,000.00	2,649,769.83
2104	Хангамж, бараа материалын зардал	32,916,672.00	28,047,885.00
210401	Бичиг хэрэг	10,310,550.00	7,384,900.00
210402	Тээвэр, шатахуун	4,043,770.00	3,129,185.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,232,000.00	17,533,800.00
210408	Бараа материал акталсны зардал	330,352.00	-
2105	Нормативт зардал	60,911,078.60	194,201,150.00

**Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210502	Хоол, хүнс	60,911,078.60	194,201,150.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,540,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	12,540,000.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,715,265.74	30,524,144.23
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,780,200.00	2,351,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,935,065.74	28,172,844.23
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	173,255,185.48	155,625,629.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,217,600.00	13,321,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,652,000.00	3,140,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	138,385,585.48	139,164,329.85
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,671,456.36	394,742.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	63,955,502.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	63,955,502.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	715,954.36	394,742.60
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	715,954.36	394,742.60
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	157,450,030.85	39,497,149.75
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,663,216.89	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,291,293.89	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,371,923.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(2,663,216.89)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	154,786,813.96	39,497,149.75

**Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,077,265,100.00	2,418,715,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	4,137,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	4,137,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	4,137,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,137,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,077,265,100.00	2,414,578,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,773,376,600.00	2,154,298,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,773,376,600.00	2,154,298,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,780,200.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,780,200.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	300,108,300.00	260,280,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	300,108,300.00	260,280,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,889,213,241.54	2,327,372,311.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,889,213,241.54	2,327,372,311.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,824,137,575.18	2,227,769,098.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,221,694,147.64	1,604,740,084.57
210101	Үндсэн цалин	800,782,420.66	986,236,284.03
210102	Нэмэгдэл	396,906,126.98	594,772,775.23
210104	Урамшуулал	24,005,600.00	23,731,025.31
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	155,219,121.16	196,311,762.78
210201	Тэтгэврийн даатгал	106,215,291.84	134,738,577.85
210202	Тэтгэмжийн даатгал	12,530,183.82	16,867,444.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,152,384.61	8,195,897.42
210204	Ажилгүйдлийн даатгал	6,013,372.83	7,301,969.35
210205	Эрүүл мэндийн даатгал	24,307,888.06	29,207,873.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	286,392,345.64	254,885,357.40
210301	Гэрэл, цахилгаан	16,361,545.64	21,052,845.18
210302	Түлш, халаалт	265,030,800.00	231,182,742.39
210303	Цэвэр, бохир ус	5,000,000.00	2,649,769.83
2105	Нормативт зардал	60,563,275.00	93,564,350.00
210502	Хоол, хүнс	60,563,275.00	93,564,350.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,000,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	13,000,000.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,715,265.74	30,524,144.23
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,780,200.00	2,351,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,935,065.74	28,172,844.23
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,553,420.00	42,743,400.00

**Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	49,330,370.00	32,691,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,223,050.00	10,051,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65,075,666.36	99,603,212.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	64,359,712.00	99,208,470.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	64,359,712.00	99,208,470.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	715,954.36	394,742.60
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	715,954.36	394,742.60
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	188,051,858.46	91,342,888.42
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	63,630,600.00	26,196,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	63,630,600.00	26,196,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	63,630,600.00	26,196,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	63,630,600.00	26,196,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(63,630,600.00)	(26,196,600.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	124,421,258.46	65,146,288.42
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	146,188,020.13	269,237,355.59
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	269,237,355.59	334,383,644.01

Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	602,708,368.54	738,350,184.68	1,422,650,122.62	2,763,708,675.84
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	498,950.43	498,950.43
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	602,708,368.54	738,350,184.68	1,423,149,073.05	2,764,207,626.27
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	154,786,813.96	154,786,813.96
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	602,708,368.54	738,350,184.68	1,577,935,887.01	2,918,994,440.23
2025 оны 01-р сарын 1-нээрх үлдэгдэл	602,708,368.54	738,350,184.68	1,577,935,887.01	2,918,994,440.23
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	602,708,368.54	738,350,184.68	1,577,935,887.01	2,918,994,440.23
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	39,497,149.75	39,497,149.75
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	602,708,368.54	738,350,184.68	1,617,433,036.76	2,958,491,589.98

Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,712,130,700.00	2,418,320,457.40	293,810,242.60	89.17
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,187,373,400.00	2,154,298,100.00	33,075,300.00	98.49
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,187,373,400.00	2,154,298,100.00	33,075,300.00	98.49
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	260,280,100.00	259,885,357.40	394,742.60	99.85
132001	Орон нутгийн төсвөөс	260,280,100.00	259,885,357.40	394,742.60	99.85
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	264,477,200.00	4,137,000.00	260,340,200.00	1.56
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,127,900.00	4,137,000.00	(9,100.00)	100.22
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	260,349,300.00		260,349,300.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,712,130,700.00	2,353,174,168.98	358,956,531.02	86.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,712,130,700.00	2,353,174,168.98	358,956,531.02	86.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,608,210,300.00	2,253,965,698.98	354,244,601.02	86.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,907,258,300.00	1,604,740,084.57	302,518,215.43	84.14
210101	Үндсэн цалин	1,203,166,400.00	986,236,284.03	216,930,115.97	81.97
210102	Нэмэгдэл	679,575,100.00	594,772,775.23	84,802,324.77	87.52
210104	Урамшуулал	24,516,800.00	23,731,025.31	785,774.69	96.79
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	238,407,300.00	196,311,762.78	42,095,537.22	82.34
210201	Тэтгэврийн даатгал	162,116,900.00	134,738,577.85	27,378,322.15	83.11
210202	Тэтгэмжийн даатгал	19,072,600.00	16,867,444.50	2,205,155.50	88.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,536,300.00	8,195,897.42	1,340,402.58	85.94
210204	Ажилгүйдлийн даатгал	9,536,300.00	7,301,969.35	2,234,330.65	76.57
210205	Эрүүл мэндийн даатгал	38,145,200.00	29,207,873.66	8,937,326.34	76.57
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	255,280,100.00	254,885,357.40	394,742.60	99.85
210301	Гэрэл, цахилгаан	22,200,800.00	21,844,487.57	356,312.43	98.40
210302	Түлш, халаалт	230,399,500.00	230,391,100.00	8,400.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	2,679,800.00	2,649,769.83	30,030.17	98.88
2105	Нормативт зардал	98,214,900.00	93,564,350.00	4,650,550.00	95.26
210502	Хоол, хүнс	98,214,900.00	93,564,350.00	4,650,550.00	95.26
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,908,600.00	30,524,144.23	2,384,455.77	92.75
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,127,900.00	2,351,300.00	1,776,600.00	56.96
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	28,780,700.00	28,172,844.23	607,855.77	97.89
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	71,141,100.00	68,940,000.00	2,201,100.00	96.91
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	60,956,100.00	58,888,300.00	2,067,800.00	96.61

**Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,185,000.00	10,051,700.00	133,300.00	98.69
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	103,920,400.00	99,208,470.00	4,711,930.00	95.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	103,920,400.00	99,208,470.00	4,711,930.00	95.47
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	103,920,400.00	99,208,470.00	4,711,930.00	95.47
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		269,237,355.59		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		334,383,644.01		

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 96,359.9 мянган төгрөгийн алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээний тайланд улсын төсвийн санхүүжилтийг 50,383.1 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.

Санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд 9.4 мянган төгрөгийн бусад зардлыг татварын орлого дансанд тайлагнасан.

Үндсэн үйл ажиллагааны 4,137.0 мянган төгрөгийн орлогыг төсвийн бусад үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор бүртгэсэн.

Орон нутгийн санхүүжилтийн 29,350.0 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтийн орлогод бүртгэсэн.

Тайлант онд худалдан авсан 12,480.4 мянган төгрөгийн номыг бусад эргэлтийн хөрөнгө (ТӨҮГ)-ын дансанд бүртгэснийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна”, 15.2-т “нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж тус тус заасны дагуу санхүүгийн тайланд залруулга хийсэн.

Аудитаар илэрсэн 23,136.5 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 24,682.9 мянган төгрөгөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Аудитаар нийт 23,288.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 3,516.6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 18,222.1 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1,397.7 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

Тайлант онд Ерөнхий боловсролын сургуулийн нэр бүхий 15 ажилтанд ээлжийн амралттай байх хугацаанд 3,516.5 мянган төгрөгийн цалин хөлс давхардуулж илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-д “ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ” гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ээлжийн амралтын хугацаанд давхардуулан олгосон цалин хөлсийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 88 ширхэг 18,222.1 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй, холбогдох байгууллагад хүсэлт өгч шийдвэрлүүлээгүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” тухай 271 дүгээр тогтоолын 7.1-д “төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж

**Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

шийдвэрлүүлнэ”, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгөнд тавих хяналтыг сайжруулж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох саналыг Төв аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж, шийдвэрлүүлэх албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 8.1.5-д "Санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8.3-д "Санхүүгийн тайлангийн тодруулга нь Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч тэдгээрийн аль нэгийг ойлгоход хамааралтай нэмэлт мэдээллээр хангана" гэж заасантай тус тус нийцэхгүй, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг тайлбар тодруулгын хамт бэлтгэж байх.

2. Өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант хугацааны эцэст 1,397.7 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 "Хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өр төлбөр үүсгэхгүй ажиллах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 20-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
								Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээний тайланд улсын төсвийн санхүүжилтийг 50,383.1 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	50,383.1			1	50,383.1	1	50,383.1		
2	Санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд 9.4 мянган төгрөгийн бусад зардлыг татварын орлого дансанд тайлагнасан.	1	9.4			1	9.4	1	9.4		
3	Үндсэн үйл ажиллагааны 4,137.0 мянган төгрөгийн орлогыг төсвийн бусад үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор бүртгэсэн.	1	4,137.0			1	4,137.0	1	4,137.0		
4	Орон нутгийн санхүүжилтийн 29,350.0 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтийн орлогод бүртгэсэн.	1	29,350.0			1	29,350.0	1	29,350.0		
5	Тайлант онд худалдан авсан 12,480.4 мянган төгрөгийн номыг бусад эргэлтийн хөрөнгө (ТӨҮГ)-ын дансанд бүртгэсэн.	1	12,480.4			1	12,480.4	1	12,480.4		
	Дүн	5	96,359.9			5	96,359.9	5	96,359.9		

Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тайлант онд Ерөнхий боловсролын сургуулийн нэр бүхий 15 ажилтанд ээлжийн амралттай байх хугацаанд 3,516.5 мянган төгрөгийн цалин хөлс давхардуулж илүү олгосон байна.	1	3,516.5	1	3,516.5								
2	Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 88 ширхэг 18,222.1 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй, холбогдох байгууллагад хүсэлт өгч шийдвэрлүүлээгүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	1				1							
3	Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.	1						1					
4	Тайлант хугацааны эцэст 1,397.7 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.	1	1,397.7					1	1,397.7				
	Дүн	4	4,914.2	1	3,516.5	1		2	1,397.7				

Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт 171 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 140 мэдээлэл, хугацаа хоцорч мэдээлсэн 21 мэдээлэл, байршуулаагүй 10 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулахаас орлогын 1,972,576.1 мянган төгрөгийн 61 гүйлгээ, зарлагын 126,732.3 мянган төгрөгийн 7 гүйлгээ хугацаа хоцорч, орлогын 239,742.7 мянган төгрөгийн 4 гүйлгээ, зарлагын 42,748.0 мянган төгрөгийн 2 гүйлгээ тус тус байршуулаагүй. Мөн худалдан авах ажиллагааны тайлан, аудитын тайлан дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тайлан тус тус байршуулаагүй байна.	1	2,381,800.0			1	2,381,800.0		-
Дүн	1	2,381,800.0			1	2,381,800.0		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Тайлант онд 26,196.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авалт хийхдээ тендер зарлаагүй шууд худалдан авалт хийсэн.	1	26,196.6					1	26,196.6
	1	26,196.6					1	26,196.6
Нийт дүн	1	2,407,966.6			1	2,381,800.0	1	26,196.6



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 46-20810579-ТӨА-2026/214/НА-СТА-ТШЗ Зуунмод сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант онд нийт 171 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 140 мэдээлэл, хугацаа хоцорч мэдээлсэн 21 мэдээлэл, байршуулаагүй 10 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулахаас орлогын 1,972,576.1 мянган төгрөгийн 61 гүйлгээ, зарлагын 126,732.3 мянган төгрөгийн 7 гүйлгээ хугацаа хоцорч, орлогын 239,742.7 мянган төгрөгийн 4 гүйлгээ, зарлагын 42,748.0 мянган төгрөгийн 2 гүйлгээ тус тус байршуулаагүй. Мөн худалдан авах ажиллагааны тайлан, аудитын тайлан дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тайлан тус тус байршуулаагүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “хариуцлагатай байх”, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1.5-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.10-д “Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудитормын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-т “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:


Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь үнэн зөв байршуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Дэлгэрмаа, нягтлан бодогч Т.Жавзандулам нарт даалгав.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

Ц.ХИШИГЖАРГАЛ

Ч.МӨНХТУЯА

Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 47-20810579-ТӨА-2026/214/НА-СТА-ТШЗ Зуунмод сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 88 ширхэг 18,222,081.90 (арван найман сая хоёр зуун хорин хоёр мянга наян нэгэн) төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй, холбогдох байгууллагад хүсэлт өгч шийдвэрлүүлээгүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.7 "нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлс", Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ" Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" тухай тогтоолын 7.1-д "төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үндсэн хөрөнгөнд тавих хяналтыг сайжруулж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох ажлыг зохион байгуулж, зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Дэлгэрмаа, нягтлан бодогч Т.Жавзандулам нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ч.МӨНХТУЯА

Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 32-20810579-ТӨА-2026/214/НА-СТА-ТШЗ

Зуунмод сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Ерөнхий боловсролын сургуулийн нэр бүхий 15 ажилтанд ээлжийн амралттай байх хугацаанд 3,516,581 /гурван сая таван зуун арван зургаан мянга таван зуун наян нэгэн/ төгрөгийн цалин хөлс давхардуулж илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-д "ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон"-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ээлжийн амралтын хугацаанд давхардуулан олгосон 3,516,581 /гурван сая таван зуун арван зургаан мянга таван зуун наян нэгэн/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж Төв аймгийн Төрийн сан дахь Тө.Хүү, торгуулийн орлогын 100 140000988 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Төв аймгийн Цээл сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Дэлгэрмаа, нягтлан бодогч Т.Жавзандулам нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ч.МӨНХТУЯА

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn